

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ЗОРИЛГО. Цэцэрлэгийн хүүхдийг эрүүл, аюулгүй, амин дэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, зөв зохистой хоололтонд шилжүүлж, өсөлт хөгжлийг дэмжинэ. **ЗОРИЛТ:**

- ❖ Хүнс нийлүүлэх байгууллагыг оновчтой сонгоно.
- ❖ Хүнс нийлүүлэгч байгууллагаас зах зээлийн хамгийн бага боломжит үнээр хүнсний бүтээгдэхүүнийг авч, төсвийн хэмнэлт үүсгэнэ.

Хүнс нийлүүлэгч байгууллагаас эрүүл ахуйн болон хүнсний аюулгүй байдлын тухай зохих хууль, дүрэм, журам, шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг баталсан хуваарийн дагуу хүлээн авна.

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИХ

ШААРДЛАГА: ❖ Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байна.

Хүнсний бүтээгдэхүүн нь шинжилгээний бичигтэй байна.

- ◆ :◆ Хүүхдийн эрүүл мэнд дур сонирхолд нийцсэн байна.
- ◆ ◆ Орон нутагт хийгдсэн шинэ гурилан бүтээгдэхүүн байх.
- ◆ ◆ Нийлүүлж буй бүтээгдэхүүн нь сав, баглаа боодол, шошготой байх.
- ◆ Бараа, бүтээгдэхүүн нь гарал үүслийн болон лабораторийн бичигтэй байх.
- ◆ :◆ Бараа бүтээгдэхүүнийг өдөр тутам нийлүүлэх боломжтой байх.
- ◆ :◆ Хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын байгууллагаас гарсан шаардлага шалгуурт нийцсэн байна.
- ◆ :◆ Хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацааг нарийвчлан бүртгэж, бүртгэл

хөтөлдөг байх.

- ◆ :◆ Байгууллагаас гаргасан хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ажлын төлөвлөгөө, хуваарийг маш сайн барина.
- ◆ :◆ Гэрээгээр хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлнэ.
- ◆ :◆ Хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтмол барина.
- ◆ :◆ Гарал үүслийн бичигтэй байх. (мах, сүү г.м)
- ◆ :◆ Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинэжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцна.
- ◆ :◆ Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байх.
- ◆ :◆ Чанарын стандартын шаардлага хангаагүй (норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу,гашилж ээдсэн, сав баглаа боодол гэмтэж урагдаж цоорсон), хугацаа дууссан бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд тухайн барааг үл маргах журмаар сольж өгнө.